

МЭДЭЭЛЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫГ  
ДЭЭШЛҮҮЛЭХЭД БҮТЭЦ ХЭЛБЭРИЙН ОНЦЛОГ НӨЛӨӨЛӨХ НЬ

Т.Өнөрсайхан\*

МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн дэд профессор, доктор (Ph.D)

**Түлхүүр үгс:** мэдээ, мэдээлэл, сурвалжилга, хөтөлбөр, хэлбэр, агуулга, телевиз.

**М**арк Квинтилиан утга санааг товч тодорхой илэрхийлэх 5W&H –ийн анхны ерөнхий чиг санааг гаргаж, мэдээллийн агентлагуудын технологийн боломж энэ хувилбарыг орчин үеийн боловсронгуй хэлбэрт ороход үндсэн үүргийг гүйцэтгэсэн юм. Интернэтээс өмнө телевиз хүртээмжтэй, олон талт, шуурхай мэдээллийн хэрэгсэл хэмээгдэж байх үед 5W&H-ийн томъёолол мэдээг төдийгүй мэдээллийн хөтөлбөрийг тодорхойлж байлаа. Технологи, урлаг, бизнесийн уулзварт ОНМХ-ийн үндсэн мөн чанарыг гол тулгуураа болгон оршдог телевизийн хөгжилд шинэ төрлийн мэдээллийн хэрэгслүүд, олон талт мэдээллийг дамжуулах боломжтой платформууд нөлөөлж анхдагч асуултуудын хүрээнд үйл ажиллагаа явуулах чиг үүрэг нь суларсан байна. Харин үйл явдлыг тэнцвэртэй, судалгаатай хүргэхэд Яаж? гэсэн асуулт агуулгын хүрээнд үндсэн цөм болж дүрсэн мэдээллийн олон талт онцлог болон өгөгдлийн холимог байдал телевизийн мэдээллийн хэв шинжийг тодорхойлох болжээ.

Мэдээллийн хөтөлбөр телевизийн үйл ажиллагааны бодлого, чиглэл, онцлогийг тодорхойлдог. Нөгөө талаар мэдээллийн хөтөлбөр нь тухайн телевизийн мэргэжлийн салбар дахь болон хүлээн авагчдын дунд өрсөлдөх чадварыг тогтвортой хангахад үндсэн үүргийг биелүүлнэ. Нийгмийн талаас нь авч үзвэл үзэгчдийн мэдээллийн хэрэгцээ- хэрэглээг хангах зорилготой, олон нийтийн ашиг сонирхлыг эрхэмлэн, олон ургалч үзлийн индэр байж, тэнцвэртэй мэдээлэл хүргэх үүрэгтэй юм. Тухайн телевизийн нэр хүндийн илэрхийлэл-брэнд болсон мэдээллийн хөтөлбөрийг цаг хугацааны тодорхой хүрээнд өрнөсөн эсвэл яг энэ цаг мөчид өрнөж байгаа анхаарал татсан үйл явдал, үзэгдлийн талаар мэдээлдэг, тогтмол цагт шинэ дугаар нь хүлээн авагчдад хүрдэг нэвтрүүлгийн хэлбэр (Мэндхүү, 2017) гэж тодорхойлно.

Зохиогч тус өгүүллээрээ телевизийн мэдээллийн хөтөлбөрийн бүтэц хэлбэрээр дамжин илрэх стратегийн талаар судалж, нэгтгэн дүгнэн бичсэн болно. Ингэхдээ онолын судалгаа хийж түүхчилсэн, харьцуулсан, мэдээлэл цуглуулах аргуудыг ашиглалаа.

Мэдээллийн хөтөлбөрийг боловсруулахдаа ерөнхийд нь агуулга,

хэлбэрийн хувьд ангилж, цааш нь цаг хугацаа, орон зай, хүртээмж, үзэгчдийн бүлгээс хамааран дэд хэсгүүдээр задалж үздэг. Ингэхдээ мэдээллийн хөтөлбөрт шууд нөлөө үзүүлэх хүчин зүйлүүдийг дараах байдлаар томъёолно. Үүнд, телевизийн бодлого, чиглэл, технологи, хөтөлбөрийн агуулга, хөтөлбөрийн бүтэц хэлбэр, хүний нөөц юм. Үндсэн сэдэв болох мэдээллийн хөтөлбөрийн бүтэц хэлбэрийн талаар өгүүлэхээсээ өмнө мэдээллийн хөтөлбөрт нөлөөлдөг бусад хүчин зүйлийн талаар товч дурдъя.

ОНМХ-ийн маркетингийн орчны хүрээнд авч үзвэл нийтлэлийн бодлого, чиглэл, технологи нь макро болон микро орчинд шууд хэлбэрээр хавсран хамаарна. Өөрөөр хэлбэл, ямар нийтлэлийн бодлогыг баримтлах нь тухайн телевизийн байр суурь, чиглэл хэдий ч энэ нь гаднаас шууд хамаарах олон хүчин зүйлтэй уялдаатай юм. Тухайлбал, нийтлэлийн бодлого чиглэлийг тодорхойлоход телевизийн бүсчлэлийн асуудал, теле компанийн тогтолцоо чухал үүрэгтэй. Үндэстэн дамнасан, хил дамнасан, орон даяар цацагддаг, бүс нутгийн, тухайлсан нэг аймаг хотын хэмжээнд цацагддаг гэсэн ангиллаас хамаарч баримтлах нийтлэлийн бодлого нь янз бүр байна. Технологийн хувьд өргөн нэвтрүүлэг, суваг телевизийн эрхээс хамаарахаас гадна нийтлэлийн бодлоготой уялдан ямар сэдэв чиглэлийн телевиз, тодруулбал зөвхөн мэдээ, мэдээллээр дагнасан мэдээллийн телевиз эсвэл зөвхөн хуваарьт хөтөлбөр явуулдаг нэвтрүүлгийн сүлжээтэй юу гэдгээс шалтгаалж тодорхойлогдоно. Эдгээр нь макро орчны бүлэгт багтдаг боловч микро орчны бусад хүчин зүйлд нөлөөлнө. Ингэхдээ мэдээллийн

хөтөлбөрийн агуулга, хэлбэрт шууд тусгалаа олдог юм.

**М**эдээллийн хөтөлбөрт шууд нөлөө үзүүлдэг бас нэг хүчин зүйл бол Мэдээллийн алба билээ. Англи хэлт орнуудад *newsroom* гэж нэрлэгддэг Мэдээллийн албыг “телевиз доторх телевиз” гэж тодорхойлж болно. Хэлний бүтэц, сэтгэлгээний онцлогоос хамаарч мэргэжлийн зарим нэр томъёо харилцан адилгүй орчуулагдан хэрэглэгддэг. *Newsroom* гэсэн үг анх ОНМХ-д зориулж мэдээ, мэдээлэл бэлтгэдэг хэсэг хүний хамтын ажлын өрөө гэсэн утгаар англи хэлтэн орнуудад ашиглагдаж байжээ. Манай мэдээ, мэдээлэл бэлтгэдэг редакц, алба гэсэн утгатай дүйх юм. Гэхдээ *Newsroom*-ийг мэдээний өрөө гэж махчлан орчуулах нь огт зохиомжгүй “модон орчуулга”, нөгөө талаар тухайн албанд ажиллаж буй сэтгүүлчдийн үйл ажиллагааг зөвхөн 5W&H-ийн түвшинд авч үзэж буй хэрэг билээ. Сэтгүүл зүйн төрөл зүйлийн шинж байдал, монгол хэлний онцлогоос хамаарч Мэдээллийн алба гэж нэрлэх нь зүйтэй юм. Хэрвээ мэдээний хөтөлбөр гэвэл зөвхөн хэн, юу, хэзээ, хаана, яаж, яагаад гэсэн асуултад хариулах мэдээ гаргадаг нэвтрүүлэг болно. Гэтэл зөвхөн мэдээ биш сурвалжилга, ярилцлага, тайлан, тойм ч энэ төрлийн нэвтрүүлэгт багтдаг учраас мэдээлсэн бичлэгийн төрөл зүйлийн цоморлог гэдэг утгаар нь *мэдээллийн* гэж тодотгох нь зөв юм. Мөн мэдээний хөтөлбөр гэвэл “хөтөлбөр” гэсэн тодорхойлолттойгоо ч зөрчилдөнө. Хөтөлбөр гэдэг нь олон талт зүйлийг багтаасан багц шинжийн нэвтрүүлгийн томъёолол билээ. Тэгэхээр мэдээлсэн бичлэгийн төрөлд багтдаг энэ олон зүйлүүдийг бүх талын хэлбэрээр илэрхийлж байгаа учраас Мэдээллийн

хөтөлбөр гэж нэрлэнэ. Нэгэнт зөвхөн мэдээ хийдэг бус мэдээ, сурвалжилга, тайлан, ярилцлага, тойм багтсан мэдээллийн хөтөлбөр хийж байгаа учраас мэдээний алба бус Мэдээллийн алба юм.

Мэдээллийн алба өдөр тутмын үйл ажиллагаа явуулахад сэтгүүлчдийн, редакторуудын, нэвтрүүлэгчдийн, зураглаачдын, техник үйлчилгээний, найруулагчдын, эвлүүлэгч компьютерын, продюсерын гэсэн нэгжүүдээс бүтнэ. Хэдийгээр олны өмнө нэвтрүүлэгч, сэтгүүлчид гардаг ч дээрх нэгжүүдийн аль нэгийг дутуу үнэлэх эсвэл давуу байдал үүсгэх боломжгүй.

**Т**елевиз нэгдмэл цул багийн хамтын хөдөлмөр юм. Гэхдээ үндсэн асуудлыг яаж сурвалжлах, хэрхэн илэрхийлэхэд сэтгүүлч агуулгын түвшинд голлох үүргийг гүйцэтгэдэг учраас үзүүлэх нөлөө харьцангуй их байдаг. Тиймээс Мэдээллийн алба дахь сэтгүүлчдийн багийг бүрдүүлэхдээ энэ мэргэжлийг хаана эзэмшсэн, хаана төрж өссөн, нас, хүйс, асуудалд хандах хандлага зэрэг олон талт байдлыг хамтатган авч үздэг. Өөрөөр хэлбэл, телевизийн мэдээллийн хөтөлбөр бол сүлд модны чимэглэл мэт байх ёстой (Дэлгэрцэцэг, 2006) гэдэг шиг Мэдээллийн албаны сэтгүүлчид ч амьдралын, насны олон талт байдлыг хангах ёстой. Энэ нь аливаа сэдвийг олон талаас нь, янз бүрийн байдлаар мэдээлэхэд чухал нөлөө үзүүлдэг юм. Тодорхой нэг асуудалд 25 настай, 45 настай, 60 настай сэтгүүлчийн хандах хандлага, эмэгтэй сэтгүүлч, эрэгтэй сэтгүүлчийн байр суурь, барууны орнууд, Азийн орнууд, дотоодын их дээд сургууль, ингэхдээ ямар чиглэлийн дээд сургуульд сэтгүүл зүйн боловсрол эзэмшсэн, хотынх уу, хөдөө орон нутгийнх уу, тэр дундаа аль аймгийнх,

ямар орчин нөхцөлд амьдарч байна, хувь хүний сонирхол зэрэг олон хүчин зүйлс нөлөөлнө.

Тиймээс сэтгүүл зүйн төвд чиглэсэн тэнцвэрт үйл ажиллагааг хангах, үзэгчдийн олон талт сонголтод нийцүүлэхэд сэтгүүлчийн хувь хүний онцлог онцгой үүрэг гүйцэтгэдэг. Цаашид аль нэгэн чиглэлээр дагнан мэргэшихэд хувь хүний сонирхлоос гадна дээрх амьдралын хүчин зүйлүүд нөлөөлж, асуудлыг гүнд сурвалжлах боломжийг бий болгодог байна. Сэлэнгийн намрын ургац хураалтад хотоос гарч мэргэжлийн сурвалжилга хийж үзээгүй, баруун дөрвөн замаас зүүн дөрвөн замын хооронд “сэтгүүл зүй” хийдэг хүнийг явуулснаас газар тариалангийн бүс нутагт төрж өссөн, хөдөө аж ахуйг сайн мэдэх сэтгүүлчийг явуулбал асуудлын гүнд орж, эх сурвалжуудтайгаа ойлголцож асуултаа тавихаас гадна, мэдээлэл боловсруулж, хүргэх чадвар илүү байх нь дамжиггүй билээ.

Мэдээллийн хөтөлбөрт шууд нөлөө үзүүлдэг хүчин зүйлүүдийн нэг болох хөтөлбөрийн агуулгыг сэдэвчлэн авч үздэг. Сэдвийн дарааллыг дараах байдлаар тодорхойлно. Үүнд,

- Олон талт маргаант байдал, осол гамшиг,
- Чухал үйл явдлыг мөшгөх /үр дүн/ – амжилт, бишрэл, хүндлэл, даган дуурайх,
- Чухал үйл явдлыг мөшгөх /үр дагавар/ - олон нийтэд нөлөөлөх байдлыг харгалзан үзэх,
- Алдартнууд,
- Шинэлэг байдал – Ер бусын зүйл, тогтсон хэм хэмжээг эвдсэн үйл явдал, үзэгдэл,
- Хүний анхаарлыг гойд татах – үзэгчдэд сэтгэл зүйн хүчтэй нөлөө үзүүлэх,

- Газар нутгийн ойр дөт байдал – аюул осол эсвэл сонин содон зүйл ойр дөт газар болсон тохиолдолд үзэгчдийн анхаарлыг татдаг.

Ингэхдээ мэдээллийг илүү хүртээмжтэй болгох үүднээс ижил төстэй байдлаар нь сэдвийг бүлэглэн хүргэхийг мэдээллийн багц гэнэ. Хөтөлбөр дэх мэдээллийн багцыг ерөнхий чиглэлийн хувьд улс төр, нийгмийн асуудал, эдийн засаг, бусад гэж ангилна. Үзэгч улс төр нийгмийн хурцадмал асуудлын талаар сонссоны дараа түүнтэй шууд холбоотой эдийн засгийн мэдээллийг авч тодорхой хэмжээгээр сэтгэл зүйн эерэг болон сөрөг өөрчлөлтөд ордог байна. Сүүлийн багц буюу урлаг соёл, хөгжилтэй тохиолдлын тухай хөнгөн мэдээ үзсэнээр мэдээллийн хөтөлбөр дуусахад гол чухал мэдээллийг ойлгож авсан ч гэлээ хүнд төвөгтэй мэдээ мэдээлэл авсан сэтгэгдлээс ангижирдаг байна.

**Х**өтөлбөр дундах мэдээллийн багцыг сэдвийн хувьд цогц болгон ангилснаар мэдээллийн олон талт байдлыг нэмэгдүүлж, үр нөлөөг дээшлүүлдэг гэж үздэг. Салангид олон үйл явдлыг ижил төстэй баримтаар нэгтгэх, нэгээс нөгөөд ургуулан шилжүүлэх зэргээр цогц мэдээлэл бүрдүүлэх нь мэдээллийн үр нөлөөг сайжруулна. Энэ нь хүлээн авагчдад үлдэцтэй нэгэн цогц мэдээлэл болж очдог. Өөрөөр хэлбэл, хоногшуулалт бий болно. Салангид уялдаа холбоо муутай олон мэдээлэл амархан мартагдаж, эсвэл 1-2 сэдвээс бусдыг хүлээн авсныхаа дараа эргэж санадаггүй байна.

Телевиз дүрслэлийн онцлог дээр тулгуурлан, нийтлэг үзэлтийн хүрээнд үйл ажиллагаа явуулдгаараа бусад мэдээллийн хэрэгслээс ялгардаг. Тиймээс энэ онцлогийг нь тодотгож,

үзэгчдийг татахад хэлбэр чухал үүрэгтэй юм. Нэгэн цогц сонирхолтой, багтаамж сайтай, олон талт мэдээллийн хөтөлбөрийг бэлтгэхийн тулд хэлбэрийн хувьд дараах байдлаар илэрхийлэмжийг бүрдүүлнэ.

*Сэдвийн төрөлжилтөөр.* Тухайн телевиз өргөн нэвтрүүлгийн эсвэл суваг телевизийн эрх бүхий байгууллага эсэхээс, мөн нийтлэлийн бодлогоос сэдвийн төрөлжилт хамаарна. Мэдээллийн хөтөлбөрийг сэдвийн хувьд: Ерөнхий мэдээллийн, сэдэвчилсэн мэдээллийн (олон улсын, спортын, урлаг соёлын, байгаль орчны г.м) гэж ангилна.

*Дэлгэцийн хэлний илэрхийлэмжээр.* Телевизийн дэлгэцийн хэлийг эрчимт дүрслэн үзүүлэх, нөлөөлөлт дүрслэн үзүүлэх, утгачилж дүрслэн үзүүлэх гэж ерөнхий гурав хувааж үздэг. Эрчимт дүрслэн үзүүлэх аргаар телевизийн дүрслэлийн онцлогийг тодотгон гаргана. Ямар ч эх бичвэргүйгээр зөвхөн дүрсээр болж буй үйл явдлыг логик дэс дараалалтай үзүүлэхэд эрчимт болон утгачилж дүрслэн үзүүлэх аргуудыг ашиглана. М.Маклюений “Хэрэгсэл өөрөө илгээлт” (Маклюен, 2003) гэсэн онолын томъёоллын биелэл нь дэлгэцийн нөлөөлөлт дүрслэн үзүүлэх арга юм. Мэдээллийн хөтөлбөрийн тайз, тайзны өнгийн сонголт, эфирээр гарч буй нэвтрүүлэгч, сэтгүүлчийн биеийн хэлэмж, гадаад дүр төрх, нэр хүнд гэсэн олон талт байдал тухайн хөтөлбөрийн цаашдын тогтвортой үргэлжлэх боломж, үзэгчдийг татах байдлыг тодорхойлдог.

*Цаг хугацаагаар.* А. 5-10 минутын богино хувилбар. Таван минутын хувилбарыг *headline* буюу товч мэдээ, 10 минутыг гол мэдээллийн гэж тодотгож ялгадаг. Зарим тохиолдол 15

минут байх хувилбар бий. Хамгийн чухал, анхаарал татсан, үзэгч зайлшгүй мэдэх ёстой гэж үзсэн мэдээ, сурвалжилга, цаг агаарын мэдээ багтдаг. Давуу тал нь богино хугацаанд онцлох чухал мэдээлэл хүлээн авна.


Б. 20-30 минутын “хатуу” мэдээллийн хөтөлбөр. Тухайн цаг мөчид болж буюу үйл явдлуудыг шуурхай хүргэдэг богино хувилбарыг бодвол мэдээллийн багтаамж сайтай байдгаараа онцлогтой юм. Насанд хүрсэн хүн янз бүрийн үйл ажиллагааны хувьд 15-20 минут тутамд анхаарал сулрах, хэлбэлзэх үйл явц ажиглагддаг байна. Өөрөөр хэлбэл, үзэгчдийн анхаарлын тогтворжилтыг хангахад “хатуу” мэдээллийн хөтөлбөрийн хурдтай, товч бөгөөд тодорхой мэдээллүүд 20-30 минутад хүрэлцэнэ гэж тооцоолдог.

В. Урт хэмжээний буюу инфотэйнмент мэдээллийн хөтөлбөр 60 минут үргэлжилнэ. Бүтэн нэг цагийн турш үргэлжилдэг мэдээллийн хөтөлбөрийг АНУ-ын “CBS” телевизийн сэтгүүлч, хөтлөгч Дон Хьюитт анх санаачилсан байна. 1968 оны есдүгээр сарын 24-нд “60 минут” мэдээллийн хөтөлбөрийн анхны дугаарыг хөтлөн явуулжээ. Ийм урт мэдээллийн хөтөлбөрийн давуу тал нь цогц мэдээлэл өгч чадна. Харин сул тал нь үзэгч эхнээс нь дуустал үзэх магадлал бага юм.

Мэдээллийн хөтөлбөрийн нийт хугацааг харгалзан үзэхээс гадна нэгж

материалын хугацааг төрөл зүйл бүрээр нь нарийвчлан авч бүтцийн хэлбэрийг бүрдүүлдэг. Энэ тухай төрөл зүйлээр илэрхийлэх дараагийн ангилалд тодорхой өгүүлнэ.

**Т**өрөл зүйлээр. Мэдээллийн хөтөлбөр нь мэдээ, сурвалжилга, тайлан, тойм, тайлбар, ярилцлага, хэвлэлийн тойм, зураглал, жижиг төрлүүдээс эмгэнэл, зарлал, цаг агаар гэх мэт төрөл зүйлийн хувьд олон талын бүтэцтэй байдаг. Төрөл зүйлийг хэлбэрийн талаас нь тайлбарлавал телемост, шууд болон шууд бус сурвалжилга, тоймчийн булан, тайлбар гэсэн хэсгүүдэд ангилна. Үзэгчдэд сонирхолтой байх, нэг мэдээллийг олон хэлбэрээр гүнзгийрүүлэн хүргэхэд ач холбогдлыг нь харгалзан мэдээллийн хөтөлбөр дэх багцыг бүрдүүлэхдээ төрөл зүйлийн олон талт байдлыг харгалзан үздэг. Тухайлбал, орон даяар цацагддаг өргөн нэвтрүүлгийн телевизийн оргил цагийн 30 минутын “хатуу” мэдээллийн хөтөлбөрийг төрөл зүйлийн хувьд төлөвлөхдөө бичлэгийн нэг зүйлийг гурваас илүү дараалуулж оруулах нь үзэгчдийг нэг хэмнэлд автуулж анхаарлыг нь сарнихад хүргэнэ гэж тооцоолдог. Тиймээс багцаар нь бичлэгийн төрлүүдийн олон зүйл хэлбэрийг сонгон боловсруулдаг юм. Дараах бүтцийн төлөвлөгөөнөөс түгээмэл хэлбэрийн жишээг харж болно.



Зураг 1. Орон даяар цацагддаг телевизийн 30 минутын мэдээллийн хөтөлбөрийн төрөл зүйлийн бүтэц.

Мэдээллийн хөтөлбөрийн нийт хугацааг харгалзан үзэхээс гадна нэгж материалын хугацааг төрөл зүйл бүрээр нь нарийвчлан авч үзэж бүтцийн хэлбэрийг бүрдүүлдэг тухай дээр өгүүлсэн. Оргил цагт цацагдах 30 минутын мэдээллийн хөтөлбөрт орох нэгж материалын тоог дунджаар 15-20 байна гэж тооцдог. Нэгж мэдээний үргэлжлэх хугацаа 20-30 секунд, нэгж сурвалжилгын үргэлжлэх хугацаа 1-1.30 минут, ярилцлага, тайлбар 3-5 минут гэж урьдчилан цагийн тооцоо гаргана. Мэдээллийн хөтөлбөр багтаамж сайтай, баттай эх сурвалжаас тодруулсан, бүрэн төгс хариулт өгөх олон талт мэдээллийн цогцолбор юм. Тийм учраас нэг минут 30 секунд

хугацаанд анхаарал татсан сурвалжилга бичиж, бүтцийн хувьд сонирхолтой байрлуулах нь мэдээллийн албаны багаас мэргэжлийн ур чадвар ихээхэн шаардана.

*Газар зүйн байрлалаар.* Макро хүчин зүйлд хамаарах дэд хэсгүүд микро хэсэгт нөлөөлж газар зүйн байрлал мэдээллийн хөтөлбөрийн хэлбэрийн бүтцийг тодорхойлох хүчин зүйл болж байдаг билээ. Телевизийн цацалтын хүрээнээс хамаарч хүлээн авагчдын онцлог янз бүр байдаг учраас мэдээллийн хөтөлбөрийн бүтцийн хэлбэрийг тодорхойлохдоо энэ онцлогийг харгалзан үздэг юм. Доорх жишээг 30 минутын “хатуу” хөтөлбөрөөр тайлбарлав.

	Үндэстэн дамнасан	Хил дамнасан/ бүс нутгийн	Орон даяар	Тухай орны бүс нутгийн	Аймаг, хотын
Нэгдүгээр багц	Дэлхий нийтийн анхаарал татсан сэдэв	Бүс нутагт хамаарах оронд болсон анхаарал татсан үйл явдал	Өөрийн орны улс төр	Бүс нутагт болсон анхаарал татсан үйл явдал	Аймаг, хотын анхаарал татсан үйл явдал
		Бүс нутагт хамаарах орнуудын улс төр			

Хоёрдугаар багц	Дэлхий нийтийн нийтлэг глобал асуудал	Бүс нутагт хамаарах орнуудын эдийн засаг	Өөрийн орны эдийн засаг	Бүс нутгийн улс төр, эдийн засгийн мэдээлэл	Аймаг хотын захиргаа, шийдвэр, бодлого, эдийн засаг зах зээл
Гуравдугаар багц	Олон улсын улс төр	Бүс нутагт хамаарах орнуудын нийгэм	Өөрийн орны нийгмийн асуудлууд	Бүс нутгийн нийгмийн мэдээлэл	Аймаг хотын иргэдийн байдал, нийгмийн мэдээлэл
Дөрөвдүгээр багц	Олон улсын эдийн засаг	Бүс нутагт хамаарах орнуудын спорт, урлаг соёл	Олон улсын мэдээлэл	Бүс нутгийн урлаг, спорт	Аймаг хотын урлаг спортын мэдээлэл
Төгсгөл	Бусад/ дэлхийн цаг агаар	Бусад/ бүс нутгийн цаг агаар	Бусад /цаг агаар, спорт, урлаг/	Бусад/ бүс нутгийн цаг агаар	Бусад/ цаг агаар

Хүснэгт 1. Телевизийн цацалтын хүрээ мэдээллийн хөтөлбөрийн бүтцийн хэлбэрт нөлөөлөх нь.

Мэдээллийн хөтөлбөрийн зорилго үзэгчдэд богино хугацаанд, бүх талын мэдээллийг тэнцвэртэйгээр, шуурхай хүргэхэд оршино. Ингэхдээ зөвхөн сонирхолтой сэдэв сурвалжлаад зогсохгүй тэр сэдвийг хэрхэн боловсруулах, хэзээ гаргах, яаж гаргах гэсэн хэлбэрийн олон талт байдлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Агуулга эхний түвшинд бичигддэг ч хэлбэр удаан хугацааны тогтвортой үйл ажиллагаа, телевизийн бизнес моделийн нэг хэсэг, дүрслэлийн урлагийн онцлогийг илэрхийлнэ. Манайд арилжааны өргөн нэвтрүүлгийн 14, найман суваг телевизээр үдэш бүр ижил сэдэвт мэдээллийн хөтөлбөр явж байна. Энэ бол түүврийн судалгаагаар гаргасан тоо юм. Гэтэл манайд 137 телевиз, 178 мэдээллийн сайт, өдөр тутмын 7-8 сонин тогтмол гарч (МХХ, 2021) үүний хажуугаар иргэд нийгмийн сүлжээгээр мэдээлэл дамжуулагчийн үүргийг гүйцэтгэж байна. Энэ тохиолдолд үзэгчид мэдээллийн хөтөлбөрийг сонгож үзэх биш харин суваг сольж байгаад хамгийн түрүүнд тааралдсан

телевизийн мэдээллийн хөтөлбөрийг санамсаргүй байдлаар үзэж байна.

Дэлхийн телевизийн бизнес модель контент маркетингийн аргад түлхүү тулгуурлах болсон өнөө үед мэдээллийн хөтөлбөр олон талын ашигтай нэгж бүтээл болоод зогсохгүй, шууд зар сурталчилгаа татах хуучин загварыг ч зэрэгцүүлэн ашиглаж болох өвөрмөц хувилбар билээ. Мэдээллийн өрсөлдөөний үед хамгийн ашигтай оргил цагуудад аль таарсан мэдээ, мэдээллийг дараалуулж гаргах бус харин үзэгчдийг татах хэлбэр, бүтцийн олон талт байдлыг ашиглан цацах нь мэдээллийн хөтөлбөрийн төдийгүй тухайн телевизийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх ач холбогдолтой юм.

#### Эшлэл

1. Мэндхүү Г. 2017. Телевизийн мэдээллийн хөтөлбөр: түүх, онол, практик. Удам соёл, УБ, х 11.
2. Дэлгэрцэцэг М. Телевиз. 2006. УБ, х 20.
3. Маклюен М. 2003. Понимание медиа: Внешние расширения человека. (Пер. Николаева В. Г). Москва.

4. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. 2021. МХХ, УБ, х 4.

**Ашигласан бүтээлийн жагсаалт**

1. Дэлгэрцэцэг М. 2006. Телевиз. УБ.
2. Мэндхүү Г., Өнөрсайхан Т. 2014. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ.
3. Мэндхүү Г. 2017. Телевизийн мэдээллийн хөтөлбөр: түүх, онол, практик. Удам соёл, УБ.
4. Монголын хэвлэл мэдээлэл өнөөдөр. 2021. МХХ, УБ.
5. Норовсүрэн Л. 2008. Сэтгүүл зүйн бичлэгийн төрөл зүйл. УБ.
6. Өнөрсайхан Т. 2019. Монголын арилжааны телевизүүд: түүх, онол, арга зүй. УБ.
7. Маклюен М. 2003. Понимание медиа: Внешние расширения человека. (Пер. Николаева В. Г). Москва.
8. Цвик В. Л. 2002. Телевизионная журналистика. М.,
9. Besse V., Desormeaux D. 2007. Television news reporting from design to delivery. P.
10. James Roman 1998. Love, light and a Dream: Television past, present and future.

**Summary**

The article discusses the analysis of television news program, newsroom. The author explained the format of news program. Reputation of TV stations is evaluated by news programs. News program for particular day should cover all fields of social life and events occurred in both home country and international level to broadcast to the common public. The different resources of public media require the specific working skill and ability from the journalists.